



## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2021/14/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: [Anhbayard@audit.gov.mn](mailto:Anhbayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: [Enhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enhtsoodolj@audit.gov.mn)

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495 Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

Аудитор: А.Сувдаа

Утас: 70342495 Цахим хаяг: [Suvdaaa@audit.gov.mn](mailto:Suvdaaa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>УСНББОУС</b>	<b>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</b>
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

Аудит № 76  
Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ Т

БУЛГАН АЙМГИЙН ХӨГЖИМТ  
ЖҮЖГИЙН ТЕАТРЫН ДАРГА  
Т.БЭХТӨР ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

000010163

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>208,239,741.38</u></b>	<b><u>217,581,507.09</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	208,239,741.38	217,581,507.09
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	170,096,435.83	173,332,341.83
35110	Тусгай зориулалттай материал	2,459,350.92	4,558,150.92
35130	Эм боох материал	167,637,084.91	168,774,190.91
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	38,143,305.55	44,249,165.26
35410	Бичиг хэргийн материал	2,625,691.00	4,090,151.00
35420	Аж ахуйн материал	11,179,770.60	15,176,570.60
35440	Түлш, шатах тослох материал	-	575,000.00
35450	Барилгын засварын материал	3,039,870.00	3,230,470.00
35470	Бусад хангамжийн материал	21,297,973.95	21,176,973.66
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>362,736,406.94</u></b>	<b><u>404,705,499.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	362,736,406.94	404,705,499.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	308,426,406.94	350,395,499.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	972,826,630.00	972,826,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(717,616,856.68)	(729,645,759.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,140,000.00	97,140,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,140,000.00)	(97,140,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,989,580.00	9,189,580.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,351,633.77)	(4,969,549.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,414,609.63	92,692,851.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(101,865,816.42)	(18,546,425.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	186,704,600.82	172,462,920.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(162,674,706.64)	(143,614,746.64)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	54,310,000.00	54,310,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	54,310,000.00	54,310,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>570,976,148.32</u></b>	<b><u>622,287,007.04</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>570,976,148.32</u></b>	<b><u>622,287,007.04</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	570,976,148.32	622,287,007.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	547,647,331.04	547,647,331.04
51101	Өмч: - төрийн	547,647,331.04	547,647,331.04
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(319,629,511.11)	(268,318,652.39)

51210	Өмнөх үеийн үр дүн	(319,629,511.11)	(319,629,511.11)
51220	Тайлант үеийн үр дүн	-	51,310,858.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	342,958,328.39	342,958,328.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>570,976,148.32</b>	<b>622,287,007.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>662,940,150.00</b>	<b>836,650,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>96,390,150.00</b>	<b>92,039,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	96,390,150.00	92,039,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,390,150.00	92,039,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,950,150.00	8,003,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,440,000.00	84,036,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>566,550,000.00</b>	<b>744,611,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	555,652,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	555,652,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,898,000.00	744,611,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	744,611,100.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,898,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>627,798,768.46</b>	<b>788,459,141.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>627,798,768.46</b>	<b>788,459,141.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	620,895,432.46	707,517,039.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	425,063,745.00	517,036,434.00
210101	Үндсэн цалин	425,063,745.00	409,049,195.81
210102	Нэмэгдэл	-	89,794,956.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	18,192,282.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,362,705.00	63,848,733.01
210201	Тэтгэврийн даатгал	36,756,017.00	44,070,785.87
210202	Тэтгэмжийн даатгал	4,324,236.00	5,207,227.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,431,228.00	4,165,782.21
210204	Ажилгүйдлийн даатгал	804,657.00	938,045.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8,046,567.00	9,466,891.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,234,124.00	61,829,050.00
210301	Гэрэл, цахилгаан	2,577,064.00	2,663,205.00
210302	Түлш, халаалт	57,829,200.00	57,829,050.00
210303	Цэвэр, бохир ус	827,860.00	1,336,795.00

**Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,800,372.79	7,245,324.29
210401	Бичиг хэрэг	429,280.00	901,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,053,900.00	1,210,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,097,200.00	900,290.00
210408	Бараа материал акталсны зардал	1,219,992.79	4,233,234.29
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	43,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	43,800.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,183,500.00	4,102,800.00
210602	Тавилга	-	5,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	158,500.00	228,500.00
210604	Урсгал засвар	3,025,000.00	3,868,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,913,800.00	336,000.00
210702	Дотоод албан томилолт	2,913,800.00	336,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,480,214.00	9,586,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,945,154.00	8,812,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,800.00	187,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,860.00	142,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	54,400.00	54,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	29,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	48,813,171.67	43,531,837.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	235,000.00	2,634,931.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,578,171.67	40,896,906.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,903,336.00	80,942,101.99
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,544,052.00	78,426,364.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,044,052.00	77,676,364.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	750,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	359,284.00	2,515,737.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,284.00	2,515,737.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>35,141,381.54</b>	<b>48,190,958.72</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	3,213,873.00	3,119,900.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	3,213,873.00	3,119,900.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	3,213,873.00	3,119,900.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>38,355,254.54</b>	<b>51,310,858.72</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>603,104,836.00</b>	<b>752,614,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,950,150.00</b>	<b>8,003,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	30,950,150.00	8,003,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	30,950,150.00	8,003,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,950,150.00	8,003,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>572,154,686.00</b>	<b>744,611,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	555,652,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	555,652,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,898,000.00	744,611,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	744,611,100.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,898,000.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,604,686.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,604,686.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>593,104,836.00</b>	<b>752,614,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>593,104,836.00</b>	<b>752,614,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>580,596,814.00</b>	<b>671,671,998.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	425,063,745.00	517,036,434.00
210101	Үндсэн цалин	391,253,657.00	409,049,195.81
210102	Нэмэгдэл	13,653,000.00	89,794,956.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,157,088.00	18,192,282.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,362,705.00	63,848,733.01
210201	Тэтгэврийн даатгал	36,756,017.00	44,070,785.87
210202	Тэтгэмжийн даатгал	4,324,236.00	5,207,227.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,431,228.00	4,165,782.21
210204	Ажилгүйдлийн даатгал	804,657.00	938,045.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8,046,567.00	9,466,891.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,234,124.00	61,829,050.00
210301	Гэрэл, цахилгаан	2,577,064.00	2,663,205.00
210302	Түлш, халаалт	57,829,200.00	57,829,050.00

210303	Цэвэр, бохир ус	827,860.00	1,336,795.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,232,780.00</b>	<b>3,136,870.00</b>
210401	Бичиг хэрэг	252,280.00	222,280.00
210402	Тээвэр, шатахуун	1,653,900.00	1,785,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,097,200.00	900,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	229,400.00	229,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>348,400.00</b>	<b>299,200.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	348,400.00	299,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,824,800.00</b>	<b>2,230,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	253,600.00	253,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	2,271,200.00	1,677,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,913,800.00</b>	<b>336,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,913,800.00	336,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,282,860.00</b>	<b>17,352,860.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,698,000.00	16,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,800.00	187,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,860.00	142,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	54,400.00	54,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	78,800.00	78,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>333,600.00</b>	<b>5,602,351.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	333,600.00	5,602,351.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,508,022.00</b>	<b>80,942,101.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,148,738.00</b>	<b>78,426,364.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,604,686.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,044,052.00	77,676,364.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	750,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>359,284.00</b>	<b>2,515,737.99</b>

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,284.00	2,515,737.99
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>10,000,000.00</b>	<b>-</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,000,000.00</b>	<b>-</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,000,000.00</b>	<b>-</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00	-
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(10,000,000.00)</b>	<b>-</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(357,984,765.65)		532,620,893.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(357,984,765.65)	-	532,620,893.78
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	38,355,254.54		38,355,254.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(319,629,511.11)	-	570,976,148.32
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(319,629,511.11)	-	570,976,148.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,647,331.04	342,958,328.39	(319,629,511.11)	-	570,976,148.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	51,310,858.72	51,310,858.72
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>547,647,331.04</b>	<b>342,958,328.39</b>	<b>(268,318,652.39)</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	580652000.00	602745552.00	753603600.00	750098362.01
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	580652000.00	592745552.00	753603600.00	750098362.01
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	574024500.00	580596814.00	673934700.00	671671998.01
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	428192100.00	425063745.00	517139100.00	517036434.00
210101	Үндсэн цалин	390485000.00	391253657.00	420390800.00	409049195.81
210102	Нэмэгдэл	13653000.00	13653000.00	77872300.00	89794956.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24054100.00	20157088.00	18876000.00	18192282.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53524100.00	53362705.00	64648600.00	63848733.01
210201	Тэтгэврийн даатгал	36396500.00	36756017.00	43961100.00	44070785.87
210202	Тэтгэмжийн даатгал	4281900.00	4324236.00	5171900.00	5207227.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3425500.00	3431228.00	4137500.00	4165782.21
210204	Ажилгүйдлийн даатгал	856400.00	804657.00	1034400.00	938045.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8563800.00	8046567.00	10343700.00	9466891.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62260400.00	61234124.00	61829200.00	61829050.00
210301	Гэрэл, цахилгаан	3597200.00	2577064.00	3000000.00	2663205.00
210302	Түлш, халаалт	57829200.00	57829200.00	57829200.00	57829050.00
210303	Цэвэр, бохир ус	834000.00	827860.00	1000000.00	1336795.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3234300.00	3232780.00	3257000.00	3136870.00
210401	Бичиг хэрэг	252300.00	252280.00	252200.00	222280.00
210402	Тээвэр, шатахуун	1655400.00	1653900.00	1787900.00	1785000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,097,200.00	1,097,200.00	987,500.00	900,290.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	229,400.00	229,400.00	229,400.00	229,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	348,400.00	348,400.00	348,400.00	299,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	348,400.00	348,400.00	348,400.00	299,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,824,800.00	2,824,800.00	2,233,600.00	2,230,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	253,600.00	253,600.00	253,600.00	253,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	2,271,200.00	2,271,200.00	1,680,000.00	1,677,000.00

**Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,921,300.00	2,913,800.00	1,460,700.00	336,000.00
210702	Дотоод албан томилолт	2,921,300.00	2,913,800.00	1,460,700.00	336,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,385,500.00	31,282,860.00	17,409,500.00	17,352,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,800,000.00	30,698,000.00	16,500,000.00	16,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,800.00	187,800.00	187,800.00	187,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,500.00	197,860.00	198,500.00	142,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	54,400.00	54,400.00	54,400.00	54,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	78,800.00	78,800.00	78,800.00	78,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	333,600.00	333,600.00	5,608,600.00	5,602,351.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	333,600.00	333,600.00	5,608,600.00	5,602,351.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,627,500.00	12,148,738.00	79,668,900.00	78,426,364.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,627,500.00	12,148,738.00	79,668,900.00	78,426,364.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	5,604,686.00	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,127,500.00	6,044,052.00	78,668,900.00	77,676,364.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	1,000,000.00	750,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>10,000,000.00</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	10,000,000.00	-	-
223001	Бусад хөрөнгө	-	10,000,000.00	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	580,652,000.00	592,206,836.00	752,611,100.00	752,614,100.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	560,652,000.00	555,652,000.00	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	560,652,000.00	555,652,000.00	-	-
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	744,611,100.00	744,611,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	744,611,100.00	744,611,100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	5,604,686.00	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	5,604,686.00	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	20,000,000.00	30,950,150.00	8,000,000.00	8,003,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	30,950,150.00	8,000,000.00	8,003,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	52.00	52.00
620001	Удирдах ажилтан	-	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	42.00	42.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	9.00	9.00

## **2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Нэмэлт санхүүжилт гараагүй болно.

## **3.Аудитын тайлан**

### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Бэхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 22-нд-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Ард иргэдийнхээ соёлын хэрэгцээг бүрэн хангаж, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлж урлагийн боловсрол олгох, орчин үеийн шаардлагад нийцсэн удирдлагын чадварлаг тогтолцоотой баг бүрдүүлж үндэсний хэмжээнд өрсөлдөхүйц чанартай уран бүтээл, уран бүтээлчдийг төрүүлэх нь манай байгууллагын эрхэм дээд зорилгоо болгож 2020 онд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

- Иргэд олон нийтийн соёл урлагийн эрэлт хэрэгцээг хангах
- Соёл урлагийн мэргэжлийн түвшин, хамрах хүрээг өргөжүүлэх
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Байгууллагаараа морин хуур тоглож сурах хөдөлгөөн өрнүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай /2020 оны 163 дугаар тогтоол/
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын 472 дугаар тогтоол/

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “15769.2 мянган төгрөгийн” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 379224.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7584.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51310.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	208239.7	217581.5	9341.8
Үндсэн хөрөнгө	362736.4	404705.5	41969.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>570976.1</b>	<b>622287.0</b>	<b>51310.9</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0	0	0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>570976.1</b>	<b>622287.0</b>	<b>51310.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0 мянган төгрөг буюу мөнгөн хөрөнгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Авлага дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12312.3 мянган төгрөг болж 775.9 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалаас 3983.1 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлснээс шалтгаалжээ.

Тайлант хугацааны эцсийн үлдэгдлээр 4558.2 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал буюу 85.3 хувь, бичиг хэргийн материал 4090.2 мянган төгрөгийн буюу 55.8 хувь, аж ахуйн материал 15176.6 мянган төгрөг буюу 35.8 хувиар тус тус өмнөх оноос өссөн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 404705.5 мянган төгрөг болж 41969.1 мянган төгрөгөөр өссөн нь бусад эх үүсвэрээс 4300.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 78566.0 мянган төгрөгөөр хөрөнгө дахин үнэлж орлогоор хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 4300.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 8175.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй тайлагнажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 622287.0 мянган төгрөг болж 51310.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийг дахин үнэлж үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 173709.9 мянган төгрөгөөр буюу 26.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн, үнэ төлбөргүй хүлээн авсан, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлого байна. Энэ нь тайлант хугацаанд цалингийн сүлжээ өөрчлөгдсөн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох болсонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 160660.4 мянган төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна. Энэ нь цалингийн шатлал, сүлжээ өөрчлөгдсөн, тэтгэвэрт 2 хүн гарсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 760478.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 760478.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4136.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 764614.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тодотголоор 11010.9 мянган төгрөгөөр бууруулж 753603.6 мянган төгрөгөөр баталсан байна.3

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх соёл урлаг хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа арга хэмжээг санхүүжүүлэхээр 752611.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 744611.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 8000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 744611.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 8003.0 мянган төгрөг, нийт 752614.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 750098.4 мянган төгрөгийг зарцуулж 2515.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 752614.1 мянган төгрөг буюу 99.87 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 102.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 799.9 мянган төгрөгөөр, хангамжийн зардлыг 120.1, норматив

зардлыг 49.2, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 56.6, бусад урсгал шилжүүлэг 1242.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт ороогүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 удаагийн 77676.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 15 тушаал шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 16635.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1330.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 7792.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 7512.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тэтгэвэрт гарсан ажилтанд ээлжийн амралт бодож олгохдоо тооцоолол буруу хийх 52.7 мянган төгрөгийг илүү олгосныг барагдуулсан,
2. Албан томилолтоор ажилласан үед 23.9 мянган төгрөгийн унаа хоолны нэмэгдэл давхардуулж олгосныг барагдуулсан.
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 740.0 мянган төгрөгийг жолоочийн хуудсыг бүрдүүлж, 40.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулалтыг барагдуулсан
4. Шатахуун зарцуулахдаа 430.0, бичиг хэргийн зардлаас 44.3 мянган төгрөгийг зардал андуурч бүртгэснийг залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 7792.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ Үүнд:

1. Цалингийн зардлаас 4 албан хаагчид нийт 689.1 мянган төгрөгийн нэг удаагийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчсөн, үнэн зөв байдал, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Төлөвлөгөөгөөр 8000.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэхээс 8003.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Орлогын 29.5 хувийн буюу 2360.0 мянган төгрөг 2019 онд орсон ч 2020 онд орлогоор хүлээн зөвшөөрсөн нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь "жинхэнэ хэрэгжилтийн" 5.1.4 дэх "үнэн зөв байх"; 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.12, 8.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 7512.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *1. Бараа материалын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Эхний хагас жилийн бараа материалыг бүртгэж тайлагнахдаа НББ-ийн тухай хуулийн 6.1-д заасны дагуу бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх зарчмыг хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, дотоод хяналт сулрах
- 1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 6.1, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тогтоолын дагуу хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### *2. Худалдан авалттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: НӨАТТ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ", 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь "бараа, ажил, үйлчилгээг

Хөгжимт жүжгийн театрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн

2.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, эрх үүргийн биелэлт хэрэгжихгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн, цаашид анхаарч ажиллана.

*3. Шилэн данстай холбоотой асуудал:*

3.1. Илрүүлэлт: Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг огт мэдээлээгүй, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 4 удаагийн 77676.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 15 тушаал шийдвэр мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.2.4, 6.4.5, 6.4.7, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.1.13, 2.2.2.3, 2.2.3.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, хуулийн хариуцлага хүлээх

3.3. Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид анхаарч ажиллана, хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ



ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

А.СУВДАА